



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,
<http://www.mongolbank.mn>

2014. 06. 02 № A-14/620

танай _____ -ны № _____ -т

Г Т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Б.ГАРАМГАЙБААТАР ТАНАА

Банкны салбар дахь Засгийн газрын цэвэр
зээлийн 2014 оны 1 дүгээр улирлын тайланг хүргүүлж
байна.

Хавсралт 5 хуудастай.

Хувийг: Сангийн яаманд.

Хүндэтгэсэн

ТЭРГҮҮН ДЭД
ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЖАВХЛАН



Б.ЖАВХЛАН
2014. 06. 02
Манайгаа
Гарын

14 2003
2014. 06. 02

Монголбанкны 2014 оны 06-р
сарын 02-ны өдрийн түүхтэй албан
бичгийн хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ТАЙЛАН

Банкны систем дэх Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ)

Төв банк болон банкуудын нэгдсэн дүнгээр 2014 оны I улирлын эцэст Засгийн газрын
өр төлбөр 2310.9 тэрбум төгрөг, хөрөнгө 2793.5 тэрбум төгрөг болж, ЗГЦЗ-ийн хэмжээ
-482.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь ЗГЦЗ өнгөрсөн улирлаас 573.3 тэрбум
төгрөгөөр буюу 54.3 хувиар өссөн үзүүлэлт байлаа (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Банкны систем дэх ЗГЦЗ (Монголбанкийг оруулсан дүн) (тэрбум ₮)

Хөрөнгө	XII.31	III.31	Өөрчлөлт	Өр төлбөр	XII.31	III.31	Өөрчлөлт
Төсвийн харилцах	1 268,2	800,8	(467,4)	ЗГҮЦ	1 780,3	2 058,3	278,0
Төгрөгийн	807,1	646,8	(160,3)	Богино хугацаатай	393,0	624,9	231,9
Валютын	461,1	153,9	(307,1)	Дунд хугацаатай	1387,3	1433,4	46,1
Төгрөгийн нөөц	386,4	389,6	3,2	ЗГ-т олгосон зээл	-	-	-
Нийгмийн даатгал	565,6	635,5	69,9	Бусад	42,7	252,5	209,9
ЗГ-ын санхүүжилт	540,1	550,6	10,6				
Бусад	118,7	417,0	298,3				
1.Нийт	2 879,0	2 793,5	(85,4)	2.Нийт	1 823,0	2 310,9	487,9
			ЗГЦЗ (2-1)		(1 056,0)	(482,6)	573,3

Банкны систем дэх Засгийн газар (ЗГ)-ын нийт өр төлбөр 2013 оны 4 дүгээр улирлаас 487.9 тэрбум төгрөгөөр буюу 26.8 хувиар өссөн бол ЗГ-ын нийт хөрөнгийн хэмжээ 85.4 тэрбум төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан байна. ЗГ-ын өр төлбөрийн өсөлтийг банкуудын эзэмшиж буй ЗГҮЦ-ны 278.0 тэрбум төгрөгийн өсөлт болон Монголбанкинд худалдсан Монгол Улсын Хөгжлийн банкны вексель тайлбарлаж байгаа бол Монголбанкин дахь ЗГ-ын валютын харилцах данс 307.1 тэрбум төгрөгөөр буурсан нь ЗГ-ын хөрөнгө буурахад голлон нөлөөлжээ.

Банкны систем дэх ЗГ-ын нийт өр төлбөрийн 7.4 хувь нь Монголбанкинд, 92.6 хувь нь банкуудад байршиж байгаа бол хөрөнгийн 45.1 хувь нь Монголбанкинд, 54.9 хувь нь банкуудад байршиж байна.

Төв банкин дахь ЗГЦЗ


Засгийн газар тайлант улиралд Монголбанкнаас зээл авах, ЗГҮЦ худалдах хэлбэрээр санхүүжилт аваагүй боловч Монгол Улсын Хөгжлийн банкнаас Монголбанкинд худалдсан 171.8 тэрбум төгрөгийн вексель ЗГ-ын өр төлбөрийг нэмэгдүүлжээ. Улсын төсвийн төгрөгийн харилцах 160.3 тэрбум төгрөгөөр, Чингис бондын хөрөнгийн зарцуулалтын улмаас ЗГ-ын валютын харилцах 307.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь ЗГ-ын нийт хөрөнгийн хэмжээ 434.3 тэрбум төгрөгөөр буурах шалтгаан болжээ. Тиймээс Төв банкин дахь ЗГЦЗ өмнөх улирлаас 606.1 тэрбум төгрөгөөр буюу 35.8 хувиар өсч, -1.1 их наяд төгрөгт хүрсэн байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Төв банкин дахь ЗГЦЗ (тэрбум ₮)

Хөрөнгө	XII.31	III.31	Өөрчлөлт
Төсвийн харилцах	1 268,2	800,8	(467,4)
Төгрөгийн	807,1	646,8	(160,3)
Валютын	461,1	153,9	(307,1)
Төгрөгийн нөөц	386,4	389,6	3,2
Бусад	38,2	68,1	29,9
1.Нийт	1 692,8	1 258,5	(434,3)
Төв банкин дахь ЗГЦЗ (2-1)			
Өр төлбөр	XII.31	III.31	Өөрчлөлт
ЗГҮЦ	-	-	-
ЗГ-т олгосон зээл	-	-	-
Бусад	-	171,8	171,8
2.Нийт		171,8	171,8
Төв банкин дахь ЗГЦЗ (2-1)			


Монголбанкин дахь ЗГ-ын нийт хөрөнгийн 51.4 хувь нь улсын төсвийн төгрөгийн харилцах, 31.0 хувь нь төгрөгийн нөөцийн дансанд, 12.2 хувь нь валютын харилцахад, 5.4 хувь нь бусад төрлийн дансанд¹ байна (Зураг 1).

Зураг 1а. Төв банкин дахь ЗГ-ын өр төлбөр



■ Хөгжлийн банкны вексель


Зураг 1б. Төв банкин дахь ЗГ-ын хөрөнгө



■ Төгрөгийн харилцах ■ Төгрөгийн нөөц
■ Валютын харилцах ■ Бусад

Зураг 2-оос харахад, 2011 оны 6 дугаар сараас 2012 оны эцэс хүртэл Монголбанкин дахь ЗГЦЗ-ийн өөрчлөлтийг улсын төсвийн төгрөгийн харилцах дансны өөрчлөлт голлон тайлбарлаж байв. Харин 2012 оны 12 дугаар сард Монгол улсын Засгийн газар 1.5 тэрбум ам.долларын бондыг олон улсын зах дээр амжилттай арилжаалж, тус бондын мөнгө Монголбанкин дахь улсын төсвийн валютын харилцах дансанд орсон нь ЗГЦЗ огцом буурах шалтгаан болжээ. Харин Чингис бондын хөрөнгийн зарцуулалттай холбоотойгоор 2013 оны 5 дугаар сараас 12 дугаар сар хүртэл улсын төсвийн валютын харилцах огцом буурч, ЗГЦЗ-ийн хэмжээ өссөн байна.

Зураг 2. Төв банкин дахь ЗГЦЗ (тэрбум ₮)



¹ Бусад торийн данс – Монголбанкин дахь улсын төсвийн валютын посцийн данс, тослийн данс, KFW-ын данс, хуримтлалын тоосон хүүний өлгөг.

Засгийн газар 2013 оны 1 дүгээр сараас хойш Монголбанкнаас зээл аваагүй бөгөөд 2013 оны 7 сард Монголбанк өөрийн эзэмшиж байсан 113.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ыг Улаанбаатар хотын банкинд худалдсанаар Монголбанкинд өр төлбөргүй болжээ. Гэвч МУХБ-наас 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдөр Монголбанкинд вексель худалдсанаар ЗГ-ын өр төлбөрийн хэмжээ өсчээ.

Банкууд дахь ЗГЦЗ

Банкууд дахь ЗГ-ын өр төлбөрийн хэмжээ өмнөх улирлаас 316.0 тэрбум төгрөгөөр буюу 17.3 хувиар нэмэгдсэн бөгөөд хөрөнгийн хэмжээ 348.9 тэрбум төгрөгөөр буюу 29.4 хувиар өсчээ. Ингэснээр ЗГЦЗ-ийн хэмжээ 2013 оны 4 дүгээр улирлаас 32.8 тэрбум төгрөгөөр буюу 5.2 хувиар буурч 604.0 тэрбум төгрөгт хүрсэн байна (Хүснэгт 3).


Хүснэгт 3. Банкууд дахь ЗГЦЗ (тэрбум ₮)

Хөрөнгө	XII.31	III.31	Өөрчлөлт	Өр төлбөр	XII.31	III.31	Өөрчлөлт
Нийгмийн даатгал	565,6	635,5	69,9	ЗГҮЦ	1780,3	2058,3	278,0
ЗГ-ын санхүүжилт	540,1	550,6	10,6	Бусад	42,7	80,7	38,0
Бусад	80,5	348,9	268,4				
1. Нийт	1 186,2	1 535,0	348,9	2. Нийт	1 823,0	2 139,0	316,0
Банкууд дахь ЗГЦЗ (2-1)					636,8	604,0	(32,8)

Нийт өр төлбөр ийнхүү өссөн нь ЗГ-аас улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг нөхөх зорилгоор банкуудад 278.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалсантай холбоотой байна. ЗГ-ын банкуудад байршуулсан төгрөгийн хугацаатай хадгаламж 195.3 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын төгрөгийн данс 69.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь ЗГ-ын хөрөнгө өсөхөд голлон нөлөөлжээ.


Банкууд дахь ЗГ-ын өр төлбөрийн 29.2 хувийг богино хугацаатай ЗГҮЦ², 67.0 хувийг дунд болон урт хугацаатай ЗГҮЦ³, 3.8 хувийг бусад төрлийн өр төлбөр⁴ эзэлжээ. ЗГ-ын нийт хөрөнгийн 41.4 хувь нь нийгмийн даатгал, 35.9 хувь нь ЗГ-ын санхүүжилт, 12.8 хувь нь төгрөгийн хугацаатай хадгаламж, 9.9 хувь нь бусад төрлийн хөрөнгө⁵ байна (Зураг 3а, 3б).

Зураг 3а. Банкууд дахь ЗГ-ын өр төлбөр



- Богино хугацаатай ЗГҮЦ
- Дунд, урт хугацаатай ЗГҮЦ
- ✖ Бусад

Зураг 3б. Банкууд дахь ЗГ-ын хөрөнгө



- Нийгмийн даатгал
- ЗГ-ын санхүүжилт
- ✖ Бусад

² 1 жил хүргэл хугацаатай ЗГҮЦ.


³ 1-ээс дээш жилийн хугацаатай ЗГҮЦ.

⁴ Бусад өр төлбөр – Банкууд дахь урьдчилж төлсөн ба хойшлогдсон татвар, хуримтлуулж тооцсон хүүний оглог

⁵ Бусад хөрөнгө – Орлогын шилжүүлэг, улсын төсвийн тусгай данс, улсын төсвийн хадгаламж, орон нутгийн төсөв

Банкууд дахь ЗГЦЗ-ийн хэмжээ 2011 оны 7 дугаар сараас 2012 оны 5 дугаар сар хүртэл тогтмол буурч байсан нь засгийн газрын санхүүжилтийн өсөлттэй холбоотой байсан бол 2012 оны 12 дугаар сараас эхлэн ЗГҮЦ-ыг Монголбанкаар дамжуулан банкуудад арилжаалах болсноор хэмжээ нь тогтмол өсч, ЗГЦЗ огцом нэмэгдэх шалтгаан болсон байна. (Зураг 4)

Зураг 4. Банкууд дахь ЗГЦЗ (тэрбум ₮)



Банкны системийн ЗГЦЗ-ийн хэмжээ 2012 оны 12 дугаар сараас хойш тогтмол нэмэгдэх болсон үндсэн шалтгаан нь Чингис бондын хөрөнгийн зарцуулалт болон ЗГҮЦ-ны арилжаа байна.

ЗГЦЗ-ийн тайланг банкуудаар болон системийн хэмжээгээр Хавсралт 1-д үзүүлэв.

ЗАСГИЙН ГАЗРЫН ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ТАЙЛАН

2014 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдааар

/сая төгрөгөөр/

БАНКУУД ДАНС	Банкууд	Улирлын есөлт /хувь/	Монголбанк	Улирлын есөлт /хувь/	БҮГД ДУН	Улирлын есөлт /хувь/
1. Засгийн газрын өр төлбөр	2 139 032,8	17,3	171 849,9	-	2 310 882,7	26,8
Урьдчилж төлсөн ба хойшлогдсон татвар	3 189,9	19,2	-	-	3 189,9	19,2
ЗГ-ын богино хугацаатай үнэт цаас	624 900,9	59,0	-	-	624 900,9	59,0
ЗГ-ын дунд хугацаатай үнэт цаас	1 433 439,3	3,3	-	-	1 433 439,3	3,3
Хуримтлуулж тооцсон хүүний өглөг	77 502,8	93,7	-	-	77 502,8	93,7
Засгийн газрын зээл	-	-	-	-	-	-
ЗГ-ын бусад төрлийн өглөг	-	-	171 849,9	-	171 849,9	-
2. Засгийн газрын хөрөнгө	1 535 041,1	29,4	1 258 485,2	(25,7)	2 793 526,4	(3,0)
Улсын төсөв	1 502 770,4	27,1	1 258 485,2	(25,7)	2 761 255,6	(4,0)
Улсын төсвийн төгрөгийн харилцах	-	-	646 847,4	(19,9)	646 847,4	(19,9)
Улсын төсвийн төгрөгийн хугацаатай хадгаламж	196 338,9	18 484,8	-	-	196 338,9	18484,8
Улсын төсвийн төгрөгийн хугацаагүй хадгаламж	202,6	286,6	-	-	202,6	286,6
Улсын төсвийн төгрөгийн нөөц	-	-	389 603,6	0,8	389 603,6	0,8
Улсын төсвийн валютын нөөц	-	-	15 815,7	316,6	15 815,7	316,6
Улсын төсвийн валютын харилцах	-	-	153 946,9	(66,6)	153 946,9	(66,6)
Улсын төсвийн валютын хугацаатай хадгаламж	160,4	(39,4)	-	-	160,4	(39,4)
Улсын төсвийн валютын хугацаагүй хадгаламж	-	-	-	-	-	-
Улсын төсвийн валютын данс (төсөл)	-	-	37 226,3	48,0	37 226,3	48,0
Орлогын шилжүүлэг (төгрөг)	18 247,4	3,7	-	-	18 247,4	3,7
Орлогын шилжүүлэг (валют)	70,6	(99,3)	-	-	70,6	(99,3)
Нийгмийн даатгал (төгрөг)	635 524,7	12,4	-	-	635 524,7	12,4
Нийгмийн даатгал (валют)	-	-	-	-	-	-
Тусгай данс (төгрөг)	69 158,1	66,7	-	-	69 158,1	66,7
Тусгай данс (валют)	32 431,7	456,4	-	-	32 431,7	456,4
Засгийн газрын санхүүжилт	550 635,9	2,0	-	-	550 635,9	2,0
Засгийн газрын авлага (KFW II)	-	-	8 201,2	7,7	8 201,2	7,7
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	-	-	6 844,1	317,6	6 844,1	317,6
Өр барагдуулах албатай хийх тооцоо	-	-	-	-	-	-
Орон нутгийн төсөв	32 270,7	724,3	-	-	32 270,7	724,3
Орон нутгийн туслай данс (төгрөгийн)	31 482,1	876,0	-	-	31 482,1	876,0
Орон нутгийн туслай данс (валютын)	788,6	14,4	-	-	788,6	14,4
3. ЗГ-ын цэвэр зээл (1-2)	603 991,7	(5,2)	(1 086 635,4)	35,8	(482 643,7)	54,3

Эх үүсвэр: Монголбанк болон банкуудын тайлан тэнцэл